



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН  
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 184/ШЗ2019/06568

Улаанбаатар хот

**Талуудын эвлэрлийг баталгаажуулах тухай**

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Хишигбаатар би,

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж Ньюмайд групп ХХК-ийн байранд байрлах, “Лэндмн ББСБ” ХК /регистрийн дугаар: 5039754/-ийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, 45 дугаар байр, 121 тоот хаягт оршин суух, эмэгтэй, Жантекей овогт Далелханы Гүлнарай /регистрийн дугаар: ПЛ87102409/-д холбогдох,

461.900 төгрөг гаргуулах тухай маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 287 дугаар эвлэрлийн гэрээг 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч хянаад,

**ТОДОРХОЙЛОХ нь:**

Өргөдөл гаргагч “Лэндмн ББСБ” ХК-ийн төлөөлөгч Б.Гантулга шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөлдөө: “Лэндмн ББСБ” ХК-ийн харилцагч Д.Гүлнарай нь манай аппликейшнээр дамжуулан гаргасан хүсэлтийн дагуу 2018 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 440.000 төгрөгийн зээлийг 21.900 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн хугацаатай 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр бүрэн эргэн төлөх нөхцөлтэйгээр, Д.Гүлнарайгийн Хаан банк дахь 5856104964 тоот дансанд шилжүүлсэн. Харилцагч Д.Гүлнарай нь үндсэн зээл болон зээлийн шимтгэлийг өнөөдрийг хүртэл төлөөгүй байна. Иймд Д.Гүлнарайгаас 461.900 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.

**ҮНДЭСЛЭХ нь:**

Уригдсан тал болох Д.Гүлнарай нь өргөдлийн шаардлага болох 461.900 төгрөгийг, улсын тэмдэгтийн хураамж 14.510 төгрөгийн хамт 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор бүрэн төлж барагдуулахаар харилцан тохиролцож эвлэрсэн байна.

Энэхүү эвлэрлийн гэрээ нь хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байх тул Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дах хэсэгт заасны дагуу талуудын эвлэрлийг баталгаажуулах нь зүйтэй гэж дүгнэлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон,

**ЗАХИРАМЖЛАХ нь:**

1.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дах хэсэгт

заасныг баримтлан, уригдсан тал Д.Гулнарай өргөдлийн шаардлага 461.900 төгрөгийг, улсын тэмдэгтийн хураамж 14.510 төгрөгийн хамт 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор төлж барагдуулахаар харилцан тохиролцсон байх тул өргөдөл гаргагч “Лэндмн ББСБ” ХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Билгүүн болон тайлбар гаргагч Д.Гулнарай нарын эвлэрлийг баталгаажуулсугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7<sup>1</sup> дүгээр зүйлийн 7<sup>1.1</sup>-д зааснаар өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид 14.510 төгрөг төлсөн болохыг дурдсугай.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4, 74<sup>1.8</sup>-д зааснаар энэхүү захирамжийг тайлбар гаргагч сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгүүлэхийг мэдэгдсүгэй.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4, 74<sup>1.9</sup>-т зааснаар маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэсэн тохиолдолд талууд давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүйг дурдсугай.

ШҮҮГЧ  Б.ХИШИГБААТАР

